

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 03 дүгээр сарын 09

№03

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Эрдмийн зөвлөлийн 1-203 тоот танхимд 14:15 цагаас 88,2 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Оюунтунгалаг, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, Я.Батцэцэг, П.Ууганбаяр, Ш.Цоож, Р.Мядагмаа, Г.Батцэцэг, Ч.Улам-Оргил, Д.Ариунболор, Г.Ариунтөгс нар оролцов.

**Хэлэлцсэн асуудал:**

1. “Сургалтын хөтөлбөрийн журам”-ын урьдчилсан төслийг хэлэлцүүлэх  
(Баг бүр өөрийн хариуцан гүйцэтгэсэн хэсгийн санал танилцуулах)
  - Багийн гишүүн
2. “ШУТИС-ийн хичээлийн хөтөлбөрийн давхардлыг арилгах, хариуцах үндсэн нэгжийг тодорхойлох ажлын удирдамж” танилцуулах, зааварчилгаа өгөх
  - Сургалт, цахим шилжилтийн газрын захирал Н.Эрдэнэхүү
3. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахтай холбоотой зарим зөвлөмж, чиглэл
  - Сургалт, цахим шилжилтийн газрын захирал Н.Эрдэнэхүү
4. Бусад асуудал

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

№	Хэлэлцүүлсэн асуудал	Санал, зөвлөмж	ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:
1.	“Сургалтын хөтөлбөрийн журам”-ын урьдчилсан төслийг хэлэлцүүлсэн (Баг бүр өөрийн хариуцан гүйцэтгэсэн хэсгийн санал танилцуулав)	Бакалаврын болон ахисан түвшний сургалтын үйл ажиллагаа зохицуулах журамтай уялдуулан холбогдох заалтуудыг засварлах; Сургалтын хөтөлбөрийн удирдлага бүлгийг хөтөлбөрийн хорооны журмаар зохицуулах; Чанарын баталгаажуулалт бүлгийг “Сургалтын хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын журам”-тай (шинээр боловсруулах) уялдуулах;	Сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт, боловсруулалт хэрэгжүүлэлтийн чиглэлд уялдуулан журмыг боловсруулах; Багууд хариуцсан бүлэг бүрт бусад багийн гишүүдийн санал, зөвлөмжийг тусган дахин сайжруулаад 3 дугаар сарын 14-ний дотор СБХА-д хүргүүлэх;
2.	“ШУТИС-ийн хичээлийн хөтөлбөрийн давхардлыг арилгах, хариуцах үндсэн нэгжийг тодорхойлох ажлын удирдамж” танилцуулан, зааварчилгаа өгөв.	Хөтөлбөрийн ерөнхий хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд тухайн ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд СБХА-тай хамтран бүрэлдэхүүн сургуулиас ирүүлсэн хичээлийн давхардлын судалгаа, ажлын удирдамжийн дагуу зохион байгуулалт хийж, уулзалт бүрээр тэмдэглэл хөтлөн, шаардлагатай тохиолдолд дараагийн уулзалтыг товлон, гарсан үр дүнг тайлагнах;	Хуваарийн дагуу ХЕХ-ны гишүүд бүрэлдэхүүн сургуулиудтай уулзалт зохион байгуулан ажиллах;
3.	Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахтай холбоотой зарим зөвлөмж, чиглэл		Сургалтын хөтөлбөрт тавигдах шалгуур, шаардлага, хичээлийн хөтөлбөрийн жишиг загварт зарим засварыг хийж бүрэлдэхүүн сургууль, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжид хүргүүлэх ажлыг СБХА-д даалгах;
4.	Бусад асуудал	НБТ-өөс “Боловсролын хуанли” саналын танилцуулга хийв.	Удирдлагын түвшинд танилцуулан, хэрэгжүүлэлтийн шийдвэр гарсан тохиолдолд ХЕХ дэмжин ажиллах;

Танилцсан:



Н.Эрдэнэхүү  
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



Г.Ариунтөгс  
/ХЕХ-ны гишүүн/